

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл:**

**“3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>6,908,073.9</b>
	1.1 Ажил олгогчийн төлөх шимтгэл	2,823,802.0
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	2,277,507.1
	1.3 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	14,543.1
	1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	146.6
	1.5 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	294,322.0
	1.6 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	6,158.8
	1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,353.8
	1.8 Бусад орлого	36,740.6
	1.9 Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	1,452,499.9
	<b>Нийт орлого</b>	<b>6,908,073.9</b>

**2/5 дугаар зүйл:**

**"5 дугаар зүйл.**2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>5,882,758.8</b>
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	5,372,757.5

1.2 Тэтгэмжийн даатгалын сан	281,082.7
1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	66,698.6
1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	162,220.0
<b>Нийт зарлага</b>	<b>5,882,758.8</b>

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг